



ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитын тайлан

АУДИТЫН КОД: САГ-2018/03/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Ахлах аудитор Р.Цолмон

Гэрээт ажилтан Э.Ундармаа

Утас: 260512 Цахим хаяг: tsolmonr@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	1
2.1 Оршил	1
2.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл.....	1
2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	2
2.5 Дотоод хяналт	3
2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	4
2.7 Шилэн дансны мэдээлэл	4
2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	5
2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.9.1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар	5
2.9.2. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн улаан буудайн талаар.....	5
2.9.3 Авлагын талаар.....	5
2.9.4. Өглөгийн талаар.....	6
2.9.5. Урьдчилж орсон орлогын талаар	7
2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.15 Аудитын үр өгөөжийн талаар	8
2.16 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан.....	11
4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	14
4.5 Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	18



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ТАРИАЛАН ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ
САНГИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
В.ҮНЭНБАТ ТАНАА

2018.03.23 № 06/827
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.



\\10.10.10\20\Bichig_KhereglYawsan_Bichig\2018\0323SAG47.Docx


071543

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2. Аудитын ТАЙЛАН

2.1 Оршил

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус сангийн захирал В.Үнэнбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, авлага, зардлын дансдад хэрэгжүүлсэн горим, сорил хэрэгжүүлснээр гарсан алдаа, зөрчлийг арилгах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл


Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 18 дугаар зүйлийн 18.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 15-наас 2018 оны 4 дүгээр сарын 1–ний хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Р.Цолмон, гэрээт ажилтан Э.Ундармаа нар хэрэгжүүлэв.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2017 оны 3 дугаар сарын 05-нд Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Аудитын баг аудитыг батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн хүрээнд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 27-нд Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн захиралд гардуулна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн эрхэм зорилго нь Хүнс, хөдөө аж ахуйн салбарын бодлогын удирдамж, үндсэн чиглэл, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөцийг бүрдүүлж, хуваарилах замаар үр тарианы үйлдвэрлэлийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

"Тариалангийн тухай" хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын 2005 оны 139 дүгээр тогтоолоор "Тариалан эрхлэлтийг дэмжих санг бүрдүүлэх, захиран зарцуулах, түүнд хяналт тавих, тайлагнах журам"-ыг батлан 2005 оны 06 дугаар сараас эхлэн Хүнс, хөдөө аж ахуйн яамны дэргэд "Тариалан эрхлэлтийг дэмжих сан"-г байгуулсан билээ. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн эрх барих дээд байгууллага нь Удирдах зөвлөл бөгөөд сан нь одоо бие даасан ажлын алба, харьяа 6 салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.17-д "Засгийн газрын тусгай сангийн захирагч тухайн сангийн төсвийн" гэж заасны дагуу тус сангийн захирал төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.


Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааны талаар ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу гаргасан байна.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй



нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 21 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нэгтгэгдсэн тус сангийн салбар байгууллагуудын аудитын дүгнэлт, өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулсан алдаа зөрчлийг нэгтгэн шалгалаа.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд төв сан, Угтаал салбар, Хөтөл салбар, Хархорин салбар, Булган салбар, Сэлэнгэ салбар, Дархан салбар зэрэг нийт 7 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Тайлант онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдэж байгаа 6 байгууллагад төрийн аудитын байгууллага, 1 байгууллагад аудитын итгэл үзүүлсэн бөгөөд бүгд аудитын Зөрчилгүй санал дүгнэлт авсан байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хэрэгжүүлсэн горим сорилын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын “Explorer-3.16” програм хангамж ашиглажээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Аудитын явцад төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод аудитын албаны үйл ажиллагаатай танилцаж, тэдний үүрэг чиглэл, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнгийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хавсаргалаа.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч буюу хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг зөрчилгүй санал дүгнэлт”

байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, мөн ЗГ-ын 2015 оны 483 дугаар тушаалаар баталсан Дотоод аудитын дүрмийн дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 11 албан хаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант онд ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны 6 дугаар сарын “Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөтөл салбарын үйл ажиллагаанд хэсэгчилсэн шалгалт хийх ажлын удирдамж”-ийн дагуу Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөтөл салбарын үйл ажиллагаанд ХХААХҮЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар хэсэгчилсэн санхүүгийн баримтын шалгалт хийсэн байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Хөтөл салбарын үрийн буудай борлуулалтын асуудлыг шалгаж үзэхэд таваарын буудайгаас 191.5 тонн үрийг 9 аж ахуйн нэгж иргэнд, Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт, зөвшөөрөлгүй олгосон байна. Мөн Таримал ургамлын үр сортын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3-т заасны дагуу “Тарих үрийн чанарын улсын стандарт хангасан, гарал үүсэл, үйлдвэрлэсэн технологи нь тодорхой, баталгаат сортын болон эрлийзийн үр боловсруулах, бусдад шилжүүлэх”-д заасан үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйгээс тарих үрийн чанарын улсын стандарт хангасан эсэхэд шинжилгээ хийлгээгүй, гарал үүсэл, үйлдвэрлэсэн технологийг тодруулалгүйгээр шууд борлуулсан байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийг батлагдсан төсвийн хүрээнд Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн ба төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд нь хяналт тавин ажилласан байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 12 дугаар сард батлагдсан хуулиар Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нэгтгэсэн төсвийг 85,673.9 сая төгрөгөөр баталсан боловч дотоодын эх үүсвэрээс олгосон зээлийн эргэн төлөлтөөр 24,000.0 сая төгрөгөөр хорогдуулан тооцож төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 3,339.4 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Тайлант онд Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангаар үндсэн үйл ажиллагааны орлогоор 37,985.1 сая, туслах үйл ажиллагааны орлогоор 19.1 сая, урьд оны үлдэгдлээс санхүүжих 5,993.2 сая, нийт 43,997.4 сая төгрөгийн орлогыг олсон байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоонд хангах хүрээнд тус сан өөрийн цахим хуудсаар <http://shilendans.gov.mn/agency/1025> байршуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу албан тушаалтан хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж байгаа эсэхийг аудитаар анхаарч үзлээ. Тариалан эрхлэлтийг дэмжих сан шилэн дансны сайтад бүрэн хамрагдсан бөгөөд шилэн дансны цахим хуудсанд 2017 онд нийт орлогын 82,250.1 сая төгрөгийн 253 мэдээлэл, зарлагын 66,804.6 сая төгрөгийн 1,142 мэдээлэл тус тус байршуулж, хуулийн хэрэгжилт 100.0 хувьтай байна.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 21 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлангийн нийт хөрөнгө болон өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүнг 0.6 сая төгрөгөөр, санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт үр дүнг 0.6 сая төгрөгөөр, мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлангийн нийт цэвэр мөнгөн гүйлгээг 90.3 сая төгрөгөөр хорогдуулж, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 0.9 сая төгрөгөөр, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 91.3 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалт, аудитын “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад дээрх нийт 183.7 сая төгрөгийн аудитын залруулга хийв.


2.9.2. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн улаан буудайн талаар

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2017 оны жилийн эцсийн байдлаар өглөгөөр тусгасан 27,311.1 сая төгрөг нь Атрын 3 дахь аяны хүрээнд 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангаас авсан 80.9 мянган тонн улаан буудайны улсын төсөвт төвлөрүүлэх ёстой үлдэгдэл төлбөр болно. Уг өглөгийг улаан буудайн хадгалалтын зардал, худалдах, худалдан авах үнийн зөрүүнээс үүссэн алдагдал, хэвийн хорогдол зэргийг тооцож Сангийн яамтай өнөөг хүртэл тулган баталгаажуулалт хийгээгүйгээс шалтгаалан барагдуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-ыг тус тус баримтлан ажиллаж, Сангийн яамтай МУХС-гийн улаан буудайн тооцоог эцэслэн баталгаажуулж, он удаан жил өглөгөөр тусгасан дээрх хөрөнгөөс 2018 онд 2,000.0 сая төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлэх талаар акт тогтоох.

2.9.3 Авлагын талаар

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эцсийн үлдэгдлээр нийт 99,733.9 сая төгрөгийн авлагатай байна. Үүнд:



- Төлбөртэй үйлчилгээний авлага 99,385.2 сая төгрөг,
- Татаас, санхүүжилтийн авлага 85.1 сая төгрөг,
- Бусад авлага 263.6 сая төгрөг тус тус байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар урьд оноос авлага 16,309.6 сая төгрөгөөр өссөн нь доорх нөхцөл байдлаас шалтгаалсан байна. Үүнд:

- Сангийн яамнаас авах татаас, санхүүжилтийн авлага 85.1 сая төгрөг,
- ЗГ-ын 2017 оны 8 дугаар сарын хуралдааны тэмдэглэлийн дагуу ЗГ-ын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Атрын 3 дахь аян”-ыг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд ОХУ-ын Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Газар тариалангийн техникийн шинэчлэл төсөл”-ийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа 10.0 сая ам.долларын техник, тоног төхөөрөмж хүлээн авсан байна. Үүнтэй холбоотойгоор тариаланчдад техник, тоног төхөөрөмжийн урьдчилгаа төлбөрийг үнийн дүнгийн 30 хувиар тооцож, үлдэгдэл төлбөрийг 2021 оныг дуустал төлөх нөхцөлтэйгээр зээлдүүлснээр дансны авлага 10,218.1 сая төгрөгөөр өссөн,
- Үндсэн үйл ажиллагааны авлага болох гурилын үйлдвэр болон тариаланчид, жимсний аж ахуй эрхлэгчид, аймгууд дахь Техник дундын үйлчилгээний төвүүдэд олгосон төрөл бүрийн тариалангийн дэмжлэгүүдийн зээлийн эргэн төлөлт ургац алдсанаас буурч нийт 12,541.2 сая төгрөгөөр авлага тус тус өссөн байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт авлагын 25.5 хувь буюу 25,316.7 сая төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, 16,225.0 сая төгрөг буюу 16.3 хувийг 1992-2013 онуудад үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагууд, 20,052.0 сая төгрөг буюу 20.1 хувь нь шүүхэд болон эвлэрүүлэн зуучлах төвд хандаж шийдвэр гаргуулсан авлага тус тус эзэлж байна. Энэ нь ЗГ-ын 2017 оны 11 дүгээр сарын хуралдааны тэмдэглэлээр гангын нөхцөл байдлын улмаас ургац алдсан аж ахуйн нэгж, иргэдийн үүссэн өр, төлбөрийн эргэн төлөх хугацаанд зохих хууль, журамд нийцүүлэн зохицуулалтын арга хэмжээ авч ажиллахыг ХХААХҮСайдад даалгаснаар аж ахуйн нэгж, тариаланчдын авлага барагдуулалтыг хойшлуулсан зэргээс шалтгаалжээ.

Шийдвэрлэсэн нь: 25,316.7 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулах, 16,225.0 сая төгрөгийн авлагын эзэн холбогдогчийг тогтоох, хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэх, авлагыг барагдуулах арга хэмжээ авах талаар албан шаардлага өгөх.


2.9.4. Өглөгийн талаар

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн эцсийн үлдэгдлээр нийт өглөг 119,721.2 сая төгрөг байна. Үүнд:

- Байгууллагад төлөх өглөг 119,119.2 сая төгрөг,
- Бусад өглөг 602.0 сая төгрөг тус тус эзэлж байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар урьд оноос өглөг 6,958.9 сая төгрөгөөр өссөн нь доорх нөхцөл байдлаас шалтгаалсан байна. Үүнд:

- Сангийн яам болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хооронд 2017 оны 12 дугаар сард байгуулсан төсвийн зээлийн гэрээний дагуу үрийн улаан буудай худалдан авахад зориулан олгосон 23,400.0 сая төгрөгөөр өглөг өссөн,
- Дамжуулан зээлдүүлэх гэрээгээр “Атрын 3 дахь аян”-ыг үргэлжлүүлэх зорилтын хүрээнд ОХУ-ын Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа “Газар тариалангийн техникийн шинэчлэл төсөл”-ийн хүрээнд нийлүүлэгдэж байгаа техник,



тоног төхөөрөмжийн 10.0 сая ам.долларын зээлийг төлөх өр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 486.7 сая төгрөг буюу нийт өглөгийн 0.4 хувийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь тайлант онд хуурайшилт ихтэй улмаас аж ахуйн нэгж, иргэд ургац их хэмжээгээр алдсанаар алдагдалд орсон, тариаланчид тариа хураалтаас шалтгаалан жил бүрийн 11 дүгээр сараас дараа оны 4 дүгээр сар хүртэл авлага, өглөгийн тооцоог баталгаажуулдгаас шалтгаалжээ. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, санхүүгийн тайлангийн “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 486.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах арга хэмжээ авах талаар зөвлөмж өгөх.

2.9.5. Урьдчилж орсон орлогын талаар

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн урьдчилж орсон орлого дансны эцсийн үлдэгдлээр 561.3 сая төгрөгөөр тусгасан ба юуны орлого болох нь тодорхойгүйгээс тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-ыг тус тус баримтлан ажиллаж, урьдчилж орсон орлогын эзэн холбогдогчийг тодорхойлж, тооцоо нийлж баталгаажуулах талаар албан шаардлага өгөх.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Тайлант онд тус сангийн төв болон салбаруудын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон санхүүгийн програмыг шинэчилснээр санхүү, нягтлан бодох бүртгэл сайжирсан байна.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 25,316.7 сая төгрөгийн авлага, 486.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, урьдчилж орсон орлого дансанд бүртгэсэн 561.3 сая төгрөг нь юуны орлого болох нь тодорхойгүй зэрэг байдал нь өмнөх удирдлагуудын санхүүгийн бүртгэлээр тавих хяналт сул байгаагаас шалтгаалан авлага, өглөгийг цаг тухай бүрд тооцоо нийлж, баталгаажуулж, барагдуулаагүйгээс он дамжсан авлага, өглөгийн хэмжээ ихэссэн байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан нийт авлага болон өглөгийн төлөлт гэрээний дагуу хугацаандаа хэрэгжсэн эсэхийг бүрэн тулгалт хийж чадаагүй болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 44,773.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 2,000.0 сая төгрөгийн зөрчилд акт, 42,103.0 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн бөгөөд аудитын явцад 183.7 сая төгрөгийн ажил, гүйлгээг стандартын дагуу залруулж, 486.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгсөн байна.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газар аудит хийж 8 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг биелүүлж ажилласан байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг ажлын баримтад хавсаргасан болно.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгов.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 82,334.5 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 1,646.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 АУДИТЫН ҮР ӨГӨӨЖИЙН ТАЛААР

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах аудитаар нийт 44,773.4 сая төгрөгийн санхүүгийн үр өгөөж бий болсныг холбогдох байгууллага хүлээн зөвшөөрсөн тул үр өгөөжийн бүртгэл /Маягт УАГ 1120/-д бүртгэсэн болно.

2.16 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэвчийн АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Өглөгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар 486.7 сая төгрөг буюу нийт өглөгийн 0.4 хувийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь тайлант онд хуурайшилт ихтэй улмаас аж ахуйн нэгж, иргэд ургац их хэмжээгээр алдсанаар алдагдалд орсон, тариаланчид тариа хураалтаас шалтгаалан жил бүрийн 11 дүгээр сараас дараа оны 4 дүгээр сар хүртэл авлага, өглөгийн тооцоог баталгаажуулдгаас шалтгаалжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, санхүүгийн тайлангийн “Оршин байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

486.7 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулах арга хэмжээ авах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт албан ёсоор ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Хэмжилт – Аж ахуйн нэгж, байгууллага ажил гүйлгээ буюу үйл явдал тайлант хугацаанд зөв дүнгээр бүртгэгдсэн ба орлого, зардлыг зөв хуваарилсан байх.

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4. Аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		141,534,628.0	149,085,209.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	231.9	6,824,842.1
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	83,424,281.9	99,734,529.5
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	7,394.4	7,394.4
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	15,147,172.1	6,114,852.1
36	НӨӨЦИЙН БАРАА	9а	42,955,547.7	36,403,591.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		28,435,688.6	78,625,778.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	28,435,688.6	78,625,778.6
39100	Газар		0.0	1,647,890.5
39200	Биет хөрөнгө		28,350,651.8	76,915,442.3
39300	Биет бус хөрөнгө	13	85,036.7	62,445.8
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		169,970,316.5	227,710,988.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		112,762,290.1	119,721,210.6
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15а, 15б	112,762,290.1	119,721,210.6
41300	Өглөг	17а, 17б	112,370,649.7	119,159,947.5
41400	Урьдчилж орсон орлого	18а, 18б	391,640.4	561,263.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		57,208,026.4	107,989,777.9
51	Засгийн газрын хувь оролцоо		57,208,026.4	107,989,777.9
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		22,925,790.9	22,926,270.9
51200	Хуримтлагдсан үр дүн		33,897,953.7	84,679,225.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		384,281.8	384,281.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		169,970,316.5	227,710,988.5

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		14,914,495.1	75,068,681.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	8,798,501.5	58,105,260.4
120	Нийтлэг татварын бус орлого		8,798,501.5	58,105,260.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		6,115,993.6	16,963,421.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	10,312,987.5	22,546,732.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ		10,198,478.4	22,545,137.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		7,702,733.5	7,561,213.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,343,172.4	1,352,897.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		146,552.5	149,625.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		254,160.7	232,931.0
2104	Хангамж, бараа материалын зардал		103,318.2	292,946.0
2105	Нормативт зардал		9,100.3	2,703.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		82,097.1	86,382.3
2107	Томилолт, зочны зардал		27,444.1	70,358.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		3,936,605.9	696,497.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,800,282.3	4,676,870.9
212	ТАТААС		2,300,064.0	14,933,635.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		195,680.9	50,288.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		114,509.1	1,595.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		4,601,507.6	52,521,948.8
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		661,511.4	102,200.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		6,333,262.6	1,061,640.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)		(1,070,243.6)	51,562,508.8

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.3 Аудит хийгдсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
3	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	58,576,323.0	-	58,576,323.0
4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(298,053.0)	-	(298,053.0)
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	58,278,270.0	-	58,278,270.0
9	Тайлант үеийн үр дүн	(1,070,243.6)	-	(1,070,243.6)
10	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	57,208,026.4	-	57,208,026.4
11	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	57,208,026.4	-	57,208,026.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(780,757.3)	-	(780,757.3)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,426,789.1	-	56,426,789.1
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		-	
19	Тайлант үеийн үр дүн	51,562,508.8	-	51,562,508.8
20	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	107,989,777.9	-	107,989,777.9




4.4 Аудит хийгдсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)		41,389,230.9	82,406,639.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		23,377,999.6	43,997,439.0
120	Нийтлэг татварын бус орлого		14,469,396.9	43,997,439.0
122	Тусламжийн орлого		8,908,602.6	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		18,011,231.3	38,409,200.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		23,476,700.6	17,847,302.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ		23,476,700.6	17,847,302.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		11,809,634.2	2,768,867.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		1,346,112.5	1,363,054.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		148,437.9	147,196.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		248,453.7	233,304.6
2104	Хангамж, бараа материалын зардал		94,740.0	98,023.7
2105	Нормативт зардал		4,458.1	6,960.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		61,801.6	110,744.9
2107	Томилолт, зочны зардал		27,206.5	70,358.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		9,876,176.5	706,672.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		2,247.6	32,553.4
212	ТАТААС		5,591,482.2	14,960,865.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,075,584.2	117,569.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)		17,912,530.2	64,559,336.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)		17,913,219.8	20,773,322.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		17,913,219.8	20,773,322.4
2200	Дотоод эх үүсвэрээр		17,913,219.8	20,773,322.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)		(17,913,219.8)	(20,773,322.4)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН		-	(36,961,404.1)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ		-	36,961,404.1
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)		(689.6)	6,824,610.1
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		921.5	231.9
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		231.9	6,824,842.1



4.5 Аудит хийгдсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	61,673,919.6	82,334,531.6	(20,660,612.0)	133.5
УРСГАЛ ЗАРДАЛ	17,873,919.6	17,778,671.8	95,247.8	99.5
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,864,719.6	2,772,567.6	92,152.0	96.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,400,513.1	1,363,054.5	37,458.6	97.3
Үндсэн цалин	1,234,533.5	1,208,964.0	25,569.5	97.9
Унаа хоолны хөнгөлөлт	144,693.6	133,596.6	11,097.0	92.3
Гэрээт ажлын хөлс	21,286.0	20,493.9	792.1	96.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	152,031.0	147,196.6	4,834.4	96.8
Тэтгэврийн даатгал	96,747.1	114,549.4	(17,802.3)	118.4
Тэтгэмжийн даатгал	13,821.0	6,767.1	7,053.9	49.0
ҮОМШӨ-ний даатгал	11,056.7	7,362.9	3,693.8	66.6
Ажилгүйдлийн даатгал	2,764.2	2,202.6	561.6	79.7
Эрүүл мэндийн даатгал	27,642.0	16,314.6	11,327.4	59.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	253,340.8	233,304.6	20,036.2	92.1
Гэрэл, цахилгаан	210,394.0	176,915.8	33,478.2	84.1
Түлш, халаалт	39,164.8	52,607.6	(13,442.8)	134.3
Цэвэр, бохир ус	3,782.0	3,781.1	0.9	100.0
Хангамж, бараа материалын зардал	101,482.9	99,073.6	2,409.3	97.6
Бичиг хэрэг	16,009.8	15,848.4	161.4	99.0
Тээвэр, шатахуун	47,543.4	44,826.4	2,717.0	94.3
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	18,977.7	19,634.7	(657.0)	103.5
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,204.2	3,958.4	245.8	94.2
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,747.8	14,805.6	(57.8)	100.4
Нормативт зардал	8,064.4	6,960.0	1,104.4	86.3
Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,064.4	6,960.0	1,104.4	86.3
Эд хогшил, урсгал засварын зардал	119,000.4	110,744.9	8,255.5	93.1
Багаж, техник, хэрэгсэл	19,115.9	18,852.7	263.2	98.6
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,194.5	3,840.6	354.0	91.6
Урсгал засвар	95,690.0	88,051.7	7,638.4	92.0
Томилолт, зочны зардал	72,481.1	70,358.0	2,123.1	97.1
Дотоод албан томилолт	72,481.1	70,358.0	2,123.1	97.1

САГ-2018/3/СТА-ЗГТС

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	723,878.8	709,322.0	14,556.8	98.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	715,341.9	703,908.8	11,433.1	98.4
Даатгалын үйлчилгээ	2,183.9	2,112.0	71.9	96.7
Тээврийн хэрэгслийн татвар	2,085.1	1,722.1	363.0	82.6
Газрын төлбөр	4,267.9	1,579.1	2,688.8	37.0
Бараа үйлчилгээний бусад зардал	33,927.1	32,553.4	1,373.7	96.0
Бараа үйлчилгээний бусад зардал	33,927.1	32,553.4	1,373.7	96.0
ТАТААС	14,963,000.0	14,960,865.5	2,134.5	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	14,963,000.0	14,960,865.5	2,134.5	100.0
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	14,963,000.0	14,960,865.5	2,134.5	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,200.0	45,238.8	961.3	97.9
Бусад урсгал шилжүүлэг	46,200.0	45,238.8	961.3	97.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	46,200.0	45,238.8	961.3	97.9
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	22,400,000.0	20,769,622.5	1,630,377.5	92.7
Стратегийн нөөц хөрөнгө	22,400,000.0	20,769,622.5	1,630,377.5	92.7
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	21,400,000.0	43,786,237.2	(22,386,237.2)	204.6
Эргэж төлөгдөх зээл	21,400,000.0	43,786,237.2	(22,386,237.2)	204.6
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	61,673,919.6	82,406,639.0	(20,732,719.4)	133.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	38,409,200.0	38,409,200.0	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	38,409,200.0	38,409,200.0	-	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	47,264,719.6	43,997,439.0	3,267,280.6	93.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,207,419.6	37,985,151.4	9,222,268.2	80.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	57,300.0	19,093.6	38,206.4	33.3
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	5,993,193.9	(5,993,193.9)	
БУСАД ЭХ ҮҮСВЭР	(24,000,000.0)	-	(24,000,000.0)	0.0
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(24,000,000.0)	-	(24,000,000.0)	0.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	231.9	(231.9)	

231.9

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
(231.9)
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	9.0	(9.0)	
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	335	333	2	99.4
БАЙГУУЛЛАГЫН ТОО	5	5	-	100.0
Төсвийн байгууллага	5	5	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	165	164	1	99.4
Удирдах ажилтан	10	10	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	62	61	1	98.4
Гэрээт ажилтан	93	93	-	100.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	165	164	1	99.4
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19	19	-	100.0
Гэрээт ажилтан	146	145	1	99.3



5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2017 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2018/3/СТА-ЗГТС
Шалгагдсан байгууллагын нэр:	Тариалан эрхлэлтийг дэмжих сан			Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн 2017 оны жилийн эцсийн байдлаар өглөгөөр тусгасан 27,311.1 сая төгрөг нь Атрын 3 дахь аяны хүрээнд 2008 онд Монгол Улсыг хөгжүүлэх сангаас авсан 80.9 мянган тонн улаан буудайны улсын төсөвт төвлөрүүлэх ёстой үлдэгдэл төлбөр болно. Уг өглөгийг улаан буудайн хадгалалтын зардал, худалдах, худалдан авах үнийн зөрүүнээс үүссэн алдагдал, хэвийн хорогдол зэргийг тооцож Сангийн яамтай өнөөг хүртэл тулган баталгаажуулалт хийгээгүйгээс шалтгаалан барагдуулаагүй байна.	2,000.0	Акт тогтоов.	1.Гүйцэтгэх захирал асан 2.Санхүү бүртгэл, төлөвлөлтийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч асан	1.Н.Ариунболд 2.Н.Уранбилэг /2013-2014 он/ 1.М.Цолмон 2.Н.Уранбилэг /2014-2015 он/ 1.С.Манансан 2.Н.Уранбилэг /2015-2016 он/
2	Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар нийт авлагын 16,225.0 сая төгрөг буюу 16.3 хувийг 1992-2013 он хүртэл үүссэн эзэн холбогдогч нь тодорхойгүй авлагууд байна.	16,225.0	Албан шаардлага өгөв.	1.Гүйцэтгэх захирал асан 2.Санхүү бүртгэл, төлөвлөлтийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч асан	1.Н.Ариунболд 2.Н.Уранбилэг /2013-2014 он/ 1.М.Цолмон 2.Н.Уранбилэг /2014-2015 он/ 1.С.Манансан 2.Н.Уранбилэг /2015-2016 он/
	Нийт дүн	18,225.0			

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**